

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.12.22**



## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.12.15-12.21

### АНУ-ЫН ИНДЕКСҮҮД ӨСӨЛТТЭЙ ХААГДЛАА.

Өнгөрөгч долоо хоногийн эхэнд хувьцаанууд унасан нь технологийн хувьцааны сулрал үргэлжилсэнтэй холбоотой байв. Ялангуяа хиймэл оюун ухаан (AI)-тай холбоотой салбар дахь үнэлгээ, зардал өндөр байгаа талаарх мэдээлэл гол индексүүдийг доош татсан. Мөн мягмар гарагт гарсан арваннэгдүгээр сарын хөдөлмөрийн зах зээлийн тайлан зэрэг холимог эдийн засгийн өгөгдлүүд зах зээлийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлсөн бололтой. Харин долоо хоногийн төгсгөлд индексүүд чиглэлээ өөрчилсөн. Үүнд инфляцийн сайн тайлан болон Micron Technology хагас дамжуулагч үйлдвэрлэгчийн орлогын сайн үзүүлэлтүүд ханшийг дэмжив. Энэ нь AI-тай холбоотой хандлагыг тодорхой хэмжээнд эерэг болгосон юм.

### АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хөдөлмөрийн статистикийн товчоо (BLS) мягмар гарагт олны анхааралд байдаг nonfarm payrolls тайланг нийтэлж, арваннэгдүгээр сард АНУ-ын ажил олгогчид 64 мянган ажлын байр нэмсэн болохыг харууллаа. Энэ нь 45 мянга гэсэн хүлээлтээс давж, аравдугаар сард 105 мянган ажлын байр алдагдсанаас хойш огцом сэргэлт байв. (Аравдугаар сарын бууралтыг АНУ-ын холбооны засгийн газрын shutdown-аас үүдсэн саатлын улмаас мөн энэ өдөр зарласан.) Аравдугаар сарын уналт нь голчлон холбооны засгийн газрын 162 мянган ажлын байр цөөрсөнтэй холбоотой байсан бол арваннэгдүгээр сарын өсөлтийг эрүүл мэндийн салбар (+46 мянга) болон барилга (+28 мянга) тэргүүлжээ. Үүний зэрэгцээ, ажилгүйдлийн түвшин арваннэгдүгээр сард 4.6 хувьд хүрч, сүүлийн дөрвөн жилээс дээших хамгийн өндөр түвшинд очив.

### СУУРЬ ИНФЛЯЦИЙН ХУРД УДААШИРЧ ЭХЭЛЛЭЭ.

Долоо хоногийн сүүлээр BLS-ээс гаргасан тайлангаар АНУ-ын инфляц арваннэгдүгээр сард хүлээлтээс илүү хөрсөж байгааг харууллаа. Хэрэглээний үнийн индекс (CPI) үнэ жилээр 2.7 гаруй хувиар өссөн нь 3.1 орчим байна гэсэн таамгаас доогуур бөгөөд есдүгээр сарын 3 орчим хувиас буурсан үзүүлэлт байв. (Аравдугаар сарын өгөгдөл нь shutdown-тай холбоотой асуудлаас болж нийтлэгдээгүй.) Хүнс, эрчим хүчийг хассан суурь инфляц мөн хугацаанд 2.6 гаруй хувиар өсөж, таамгаас доогуур гарсан төдийгүй 2021 оны гуравдугаар сараас хойших хамгийн бага түвшин болов. CPI-ийн томоохон бүрэлдэхүүн болох орон сууцны зардлын инфляц жилийн суурьтайгаар 3 орчим хувь болж, 2021 оны наймдугаар сараас хойших хамгийн доод түвшинд хүрэв. Shutdown-тай холбоотой мэдээлэл цуглуулахад хүндрэл байсан ч, хүлээлтээс доогуур инфляцын тоо нь тайлан гарсны дараа зах зээл нээгдэхэд хувьцаанууд өсөхөд эерэгээр нөлөөлсөн бололтой.

Арванхоёрдугаар сард АНУ-ын бизнесийн идэвхийн өсөлт саарсан байна. Flash U.S. Composite PMI индекс 54.2-оос 53.0 болж буурч, (50-аас дээш үзүүлэлт нь тэлэлтийг илэрхийлдэг) сүүлийн зургаан сарын хамгийн доод түвшинд хүрлээ. Үйлдвэрлэл болон үйлчилгээний аль аль салбарт өсөлт удааширч, ирэх жилийн бизнесийн итгэл буурсан бол үнийн дарамт “мэдэгдэхүйц нэмэгдэв” гэж тайланд дурджээ.



## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.12.15– 12.21

### ХЯТАДЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ТЕХНОЛОГИ, AI-ИЙН НӨЛӨӨГӨӨР ӨСЛӨӨ.

Эх газрын Хятадын хувьцааны зах зээлүүд долоо хоногийг холимог гүйцэтгэлтэйгээр өндөрлүүллээ. Эдийн засгийн өсөлт сул байгааг илтгэх гурван гол үзүүлэлт зах зээлд дарамт учруулсан байна. FactSet-ийн мэдээлснээр, дотоодын гол индекс болох CSI 300 индекс 0.28 орчим хувиар буурч, Shanghai Composite индекс 0.03 орчим хувиар өслөө. Харин Хонконгт Hang Seng индекс 1.10 гаруй хувиар унав.

Bloomberg-ийн мэдээлснээр, Хятадын Үндэсний статистикийн газрын (NBS) өгөгдлийг эш татан, жижиглэн худалдааны борлуулалт арваннэгдүгээр сард өмнөх оны мөн үеэс 1.3 орчим хувиар өссөн нь цар тахлын үеэс хойших хамгийн удаан өсөлт байв. Тогтмол хөрөнгө оруулалт оны эхний 11 сард 2.6 гаруй хувиар буурч, эдийн засагчдын таамгаас доогуур гарснаар 1998 оноос хойших өгөгдлүүдээс харахад анх удаа жилээрээ агших эрсдэлтэй болжээ. Мөн аж үйлдвэрлэл таамгаас дутуу гарч, жилээрээ 4.8 орчим хувиар өссөн нь дотоод эрэлт сул хэвээр байгааг, эдийн засгийг хөдөлгөхөд экспортын салбарын ач холбогдол өндөр хэвээр байгааг онцолж байна.

Сүүлийн үеийн жижиглэн худалдааны тоо баримтаас харахад, засгийн газрын эрэлтийг дэмжих оролдлогууд үргэлжилж байгаа ч хэрэглээ Хятадын эдийн засгийн сул цэг хэвээр байна. Арванхоёрдугаар сарын эхээр Хятадын удирдлагууд ирэх онд өдөөлтийн бодлогыг огцом нэмэгдүүлэхээс зайлсхийхээ илэрхийлсэн хэдий ч өсөлтийг дэмжинэ гэж мэдэгдсэн.

Ирэх жилийн эдийн засгийн бодлогын чиглэлийг тодорхойлдог Төв эдийн засгийн ажлын хуралын дараах мэдэгдэлд дурдсанаар, Хятад улс 2026 онд хүүгийн түвшин болон заавал байлгах нөөцийн хэмжээг “уян хатан, үр ашигтай” байдлаар ашиглаж, зах зээлийн хөрвөх чадварыг ханган, “шаардлагатай” түвшний төсвийн алдагдал, зардлыг хадгална гэжээ. Шинжээчид энэхүү мэдэгдлийг Бээжин үйлдвэрлэлд суурилсан одоогийн өсөлтийн стратегиа баримтлан, үүний зэрэгцээ хэрэглээг дэмжих алхмуудыг хэрэгжүүлсээр байх дохио гэж тайлбарлаж байна.